

Сум суурин газрын цахилгаан эрчим хүчиний хэрэгцээг нарны зайгаар хангах боломж

М.Баатархүү¹ Ш.Чадраабал^{1*} М.Дүгээрсүрэн¹ Г.Батсүх^{2**}

¹ШУТИС Материалын технологийн их сургууль,

²МУИС Геофизикийн судалгааны төв

mbkhuu@musi.edu.mn

Товч утга: 21-р зууны дэлхий дахины тогтвортой хөгжлийн чиг хандлага үзэл баримтлалын дагуу байгаль орчин эрчим хүчиний асуудалтай нягт уялдуулан манай орны эрчим хүчиний хөгжлийн чиг хандлага хангамжийн асуудлыг авч үзжээ. Сүүлийн жилүүдэд дэлхий даяараа агаарын божирдолтой тэмцэж байгаа болон эрчим хүчиний уламжлалт их үүсвэрүүд дусах талруугаа орж байгаатай уялдуулан сэргээгдэх эрчим хүчийг өргөнөөр ашиглах шаардлагатай болж байгаа юм. Манай улсын хөдөөгийн сум суурин газрын эрчим хүний хэрэглээг дэлхийн улс орнуудын хөгжлийн чиг хандлагын дагуу сэргээгдэх эрчим хүний эх үүсгэвэрээр хангах нь чухал байна. Сумын цахилгаан эрчим хүчиний өнөөгийн байдал, цаашдын хэрэгцээг жижиг чадлын нарны станцаар хангах (НЦС) боломжийн тухай өгүүлнэ.

ОРШИЛ

Эрчим хүчиний хангамжийн асуудал альч улс орны дэд бүтцийн тулгуур асуудал байдаг бөгөөд манай орны хувьд ч, ялангуяа төвөөс алслагдсан нутгийн хувьд ойрын хугацаанд шийдвэрлэвэл зохих чухал асуудал юм.

Манай улс 1960-аад оноос эхлэн ХАА-н нэгдлийн төвүүдэд суурилуулсан цаг уурын ажиглалтын станцуудаас эхлэн нарны цацрагийн хэмжилтийг хийж эхэлсэн. 1986 оны үед Е.Гираагийн бичсэн номонд (анх) нарны нийлбэр цацрагийн хэмжээг (Сүүлийн 30 жилийн судалгаагаар) тооцож гаргасан. Хэдийгээр хүйтэн өвөлтэй ч нартай Монгол гэж нэрлэгдэх манай орны хувьд сэргээгдэх эрчим хүч түүний дотор нарны эрчим хүчийг төвөөс алслагдсан сум баг суурин газруудын эрчим хүчиний эх үүсвэр болгож ашиглахад нэн тохиромжтой юм. Манай улс нарны эрчим хүчиний үлэмж их өнөөцтэй бөгөөд харьцангуй сэргүүн уур амьсгалтай бүс нутагт байдаг. Олон жилийн дундажаар үзэхэд жилийн 300 гаруй өдөр цэлмэг байдаг бөгөөд нарны гийгүүлэх хугацаа жилд 2600-3000 цаг, жилд тусах эрчим хүчиний хэмжээ нийт нутгийн хэмжээгээр дундажаар 1400 квт цаг/м², нарны эрчим өдөрт 4,3-4,7 квт.ц/м байгаа нь нарны эрчим хүч ашиглах таатай нөхцөл бүрдүүлдэг.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Одоогийн байдлаар манай улсын 130 гаруй сум төвлөрсөн системд холбогдоогүй, сумын төвийнхэн цахилгаан хангамжиндаа 60-100 кВт-ын чадалтай дизель станцыг ашиглаж байна. Дизель түлшийг импортоор өндөр

үнээр худалдан авч алс хол зайд тээвэрлэхэд үлэмж хэмжээний зардал хөрөнгө шаарддаг, негеө талаас сумын төвийн хэрэглэгчдийн тоо цөөн, цахилгааны хэрэглээ бага, хэрэглэгчдээс авч байгаа цахилгааны үнэ өртөг дизелийг байнга ажилтуулаж шатахуун болон ашиглалтын зардлыг нөхөж чадахгүй байна.

Энэ учир төвийн эрчим хүчээс алслагдсан сумдын төвийн эрчим хүчиний хангамжийг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, байнгын найдвартай эх үүсгэвэртэй болохын тулд сэргээгдэх эрчим хүчиний эх үүсвэр нэн ялангуяа нарны эрчим хүчийг өргөн ашиглах замаар сум суурин газрыг цахилгаанжуулах, хаана ямар хүчин чадалтай нарны цахилгаан станц барихыг урьдчилан судалж техник эдийн засгийн үндэслэл боловсруулах шаардлагатай байна. Энэ нь тогтвортой хөгжлийн стратегийн зорилтын чухал хэсэг юм.

Сэргээдэх эрчим хүчийг ашиглах талаар дэлхий нийтийн хөгжлийн хандлага, судалгаа, туршилтын ажлын үр дүн, үйлдвэрлэлийн техник технологийн хөгжлийн өнөөгийн түвшин аль ч улс орны эрчим хүчиний хангамжинд нар, салхины эрчим хүчийг өргөн ашиглах нөхцөл нэгэнт бүрдснийг 2004 оны 5-р сард ХБНГУ-ын Бонн хотод болсон олон улсын дээд хэмжээний уулзалтаас дэлхий дахинд тунхагласныг зарласан билээ.


ТАСИС хөтөлбөр, японы НЭДО болон Жайка-гаас хэрэгжүүлсэн төслийд нилээд өндөр нарийвчлалтай тоног төхөөрөмжөөр нарны эрчим хүчиний хэмжилтийг хийсэн тул энэ талаар тоо баримт хангалттай болсон

байна. Хөдөө орон нутгийн цахилгаанжуулалтанд нарны эрчим хүч бусад эрчим хүчиний эх үүсвэрүүдээс илүү давуу, боломжтой гэдэг нь өмнө дурьдсан хэмжилтээр нотлогдсон юм. Ялангуяа хэт алслагдсан газруудад цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх өртөг, зардал их мөртлөө ачаалалт багатай нөхцөлд нарны эрчим хүчийг ашиглах нь хөдөөд цахилгаан эрчим хүч хүргэх хамгийн бага өртөгтэй хувилбарын нэг юм. Бид энэ бүтгийг нэгтгэн авч нарны цахилгаан станц байх, хэрэгцээ шаардлагыг судлан ажлын горимыг гаргасан болно. Хийгдсэн судалгаанаас үзвэл сумын хэрэглэж буй цахилгаан эрчим хүчиний хэмжээ 45-80 квт орчим байгаа юм. Энэ учраас сумын эрчим хүчиний хэрэгцээг нарны цахилгаан станцаар хангах бүрэн боломжтой байна. Манай орны зарим сумын цахилгаан эрчим хүчиний хэрэглээг улирлаас хамааруулан судалсан байдлыг 1-р хүснэгтэнд үзүүлэв.

Сумуудын цаашидын хөгжил, хүн амын өсөлт хэрэглээг тооцож 2015 онд байх цахилгаан эрчим хүчиний шаардагдах хэмжээг бодож гаргасныг 2-р хүснэгтэнд үзүүлэв.


Сумдын цахилгаан эрчим хүчиний хоногийн хэрэглээг цагаас хамааруулан авч үзвэл дараах байдалтай харагдаж байна.

Завхан аймагийн завхан мянган сумын хийгээ судалгаа (зув)




Зураг 1

1-р зургаас харахад хэрвээ сумын төвийг 24 цаг цахилгаанаар хангана гэж үзвэл оройн 18:00-21:00 хооронд ачаалалт дээд цэгтэй хүрч бусад үед бараг ачаалалгүй байна. Эндээс сумын төвийг бага чадлын цахилгаан эрчим хүчиний эх үүсвэрээр тасралтгүй хангаж болно гэж дүгнэж байна.



Зураг 2

2-р зурагт нарны байх хугацаа, сарын хамааралыг харуулав. Үүнээс харахад нарны гийгүүлэх хугацаа 3-11 сар хүртэл их байна. Өөрөөр хэлбэл энэ үед нарны цахилгаан станц нь цахилгаан эрчим хүчийг их үйлдвэрлэнэ гэсэн үг юм.



Зураг 3

3-р зурагт нэгж талбай (wt/m^2) дээр ирж байгаа нарны нийлбэр цацрагын хэмжээг саруудаар гаргасныг харахад 11,12 сараас бусад үед нарны нийлбэр цацрагын хэмжээ их байгаа нь нарны цахилгаан станц цахилгаан эрчим хүчийг зохих хэмжээгээр үйлдвэрлэх боломжтой юм. Эдгээр тооцоог Дорноговь аймгийн төв Сайншандад сууринуулсан хэмжилтийн станцын 3 жилийн дунг үндэслэн дунджаар бодож гаргасан бөгөөд эдгээр хэмжилт, тооцооны үндсэн дээр сум суурин газрын цахилгаан эрчим хүчиний үндсэн хэрэгцээг бага чадлын нарны цахилгаан станц барих замаар хангаж болно гэж дүгнэж байна.

НОМ ХЭВЛЭЛ

- [1] Establishment of development programme for small hydropower plants in the zavkhan, khuvsgol and khovd districts of Mongolia тайлан 2002 он
- [2] М.Баатархүү, Т.Одгэрэл. Нарны зайд, түүний хөдөө орон нутагт ашиглах нь ХААИС, Байгалийн ухааны сургуулийн эрдэм шинжилгээний бичиг 2003 он
- [3] Дорноговь аймгийн сайншандад хийсэн наарны цацрагын хэмжилтүүн дүн 2003-2005 он

Резюме: Рассматриваются вопросы развития энергетики нашей страны в связи с тенденцией устойчивого развития 21-ого столетия во всем мире. В последние годы настоятельно требуется широкое использование возобновляемых источников энергии вследствие атмосферного загрязнения, происходящего во всем мире и неотвратимого исчерпывания традиционных источников энергии. Весьма важным является обеспечение энергетических нужд жителей сельских поселений и сомонов в соответствии с тенденций развития энергетики ведущих стран нашей планеты. В этой статье рассматриваются сегодняшнее состояние энергетики удаленных сомонов и возможности снабжения их энергетических нужд фотovoltaическими станциями малой мощности.

1-р хүснэгт

Сум	Өвлийн улирал (11-4 сар)		Зуны улирал (5-10 сар)		Нийлбэр дүн	
	Хамгийн их чадал (kW)	MWh	Хамгийн их чадал (kW)	MWh	Хамгийн их чадал (kW)	MWh
Эрдэнхайрхан	68	70,3	30	35,6	68	105,9
Ургамал	35	49,6	22	27,5	35	69,4
Завханмандал	50	54,7	30	35,0	50	89,8

2-р хүснэгт

Сум	Өвлийн улирал (11-4 сар)		Зуны улирал (5-10 сар)		Нийлбэр дүн	
	Хамгийн их чадал (kW)	MWh	Хамгийн их чадал (kW)	MWh	Хамгийн их чадал (kW)	MWh
Эрдэнхайрхан	91	95,1	40	47,0	91	142,1
Ургамал	47	56,1	28	36,0	47	92,8
Завханмандал	64	70,2	38	44,1	64	114,3